



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Судалгаа шинжилгээний газрын дарга
А.Мөнхболд доктор Ph.D

Агуулга

1

ТХХТ-ийн бодлогын хэрэгжилт /чанарын шинжилгээ

2

ТХХТ-ийн бодлогыг шинэчлэн боловсруулах үндэслэл

3

ТХХТ-ийн тухай хуулийг шинээр боловсруулах үндэслэл

4

ТХХТ-ын бодлогын хэрэгжилтийн тоон шинжилгээ

5

ТХХТ-ийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээл

6

ТХХТ-ийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага

7

ТХХТ-н бодлогыг шинэчлэхэд анхаарах зүйлс

8

ТӨР, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, эрхзүйн шинэчлэлээс хүлээх үр дүн

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЧАНАРЫН ШИНЖИЛГЭЭ

- УИХ-аас 2009 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн /цаашид “ТХХТ” гэх/ талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг, 2010 онд Концессын тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн.
- Төсвийн тухай хуулийн Төр ба хувийн хэвшлийн түншлэл гэсэн 30 дугаар зүйлд ТХХТ-ийн хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх суурь зохицуулалт болон Өрийн удирдлагын тухай хуульд улс, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээнд тавих шаардлагыг тусгасан байна.
- Хөрөнгө оруулалтын тухай, Чөлөөт бүсийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай зэрэг 10 гаруй хуульд тухайн төсөл, арга хэмжээг концесс болон ТХХТ-ийн дагуу, эсхүл ТХХТ-д тулгуурлан хэрэгжүүлнэ гэж заасан боловч чухам тухайн түншлэлийг хэрхэн хэрэгжүүлэх, төр болон хувийн хэвшил ямар оролцоо, чиг үүрэгтэй нь тодорхойгүй, санхүүжилтийг хэрхэн шийдэх, ТХХТ-ээр хэрэгжүүлэх төслийг хэрхэн сонгох, эрэмбэлэхтэй холбоотой зохицуулалт, эрх зүйн орчин бүрхэг
- ТХХТ-ийн талаарх нэгдсэн бодлого, үзэл баримтлалыг бий болгох, дээр дурдсан хууль тогтоомжууд дахь ТХХТ болон Концесстой холбоотой зохицуулалтуудын уялдаа холбоог боловсронгуй болгох, ТХХТ-ийн тухай шинэ хуулийг боловсруулах, улмаар төр болон хувийн хэвшлийн тогтвортой, үр дүнтэй, харилцан ашигтай түншлэлд зориулсан хууль, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх шаардлагатай байна

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

- МУТХҮБ-2030”-д эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүрээнд *“эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ”* гэж заасан
- Тогтвортой хөгжлийн засаглалын хүрээнд *“төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ”* гэж заажээ.
- Одоо мөрдөгдөж байгаа ТХХТ-н бодлого 2009 онд батлагдсан ба 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар Төрөөс баримтлах бодлогын үргэлжлэх хугацааг 8-10 жил гэж заасаны дагуу энэ жил хугацаа нь дуусгавар болж байна.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

- Концессын тухай хууль баталсанаас хойш нийт 13 удаагийн нэмэлт өөрчлөлт хийж 8 заалтыг хүчингүй болгож, 44 заалтанд нэмэлт хийсэн. Нийт 8 бүлэгт нэмэлт өөрчлөлт хийгдсэн нь 60 гаруй хувь нь өөрчлөгджээ.


- КОНЦЕССЫН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2016 оны Засгийн газрын 37-р тогтоол

- МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ТОГТООЛ

13/“Барих-Шилжүүлэх” нөхцөлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлах болсонтой холбогдуулан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байх

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР БОДЛОГЫН ТООН ШИНЖИЛГЭЭ

Барих-Шилжүүлэх
Төсвөөс эргэн төлөгдөх хуваарь
/сая төгрөг/



Нийт 26 Барих-Шилжүүлэх (BT) төсөл хэрэгжиж байгаагаас концессын Төслүүдийн эргэн төлөлт 2020 онд хамгийн өндөр байхаар байна

БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭЛ




Барих-Шилжүүлэх (BT) –ээс бусад төрлийн 14 төсөл хэрэгжиж байгаагаас 100% гүйцэтгэлтэй төсөл 1 байна.

“Нарийнсухайт-Шивээхүрэнгийн автозамын төсөл”

МИНИМУМ ОРЛОГЫН БАТАЛГААНЫ АСУУДАЛ


MINIMUM REVENUE GARANTY



- Хүлээгдэж буй орлого үйл ажиллагааны бодит орлого доогуур байвал зөрүүг ЗГ төлж болно.
- Хэрэв үйл ажиллагааны бодит орлого нь хүлээгдэж буй орлогоосоо давсан бол, өмнө нь төлсөн дүнгийн хязгаар дотор ЗГ-т эргэн төлөгдөх болно.

ТХХТ-ИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ

- ТХХТ-ийн төслүүд ТЭЗҮ-ийг үнэлэх
 - 1-р шат (ТЭЗҮ): Эдийн засаг ба улс төрийн боломж ($AHP \geq 0.5$)
 - 2-р үе шат (Мөнгөн тестийн үнэ цэнэ): ТХХТ-ийн худалдан авалт нь засгийн газрын худалдан авалтаас илүү байвал ($VFM > 0$)
 - 3-р үе шат (ТХХТ-ийг хэрэгжүүлэх хувилбараар төлөвлөх): Төслийн өртөг, хэрэглэгчийн төлбөрийн түвшин, төсвийн дэмжлэгийн хэмжээ зэргийг тооцоолох.



ТХХТ-ИЙН ТӨСЛИЙГ СОНГОХ ЗАРЧИМ

< Хэзээ ТХХТ сонгох >



УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 2018-2021


	Төсөвт өртөг /сая төг/	2018-2020 /сая төг/
Улсын төсөв*	1,059,700.8	725,098.8
Гадаад зээл, тусламж*	8,704,500.7	6,634,424.1
Холимог эх үүсвэртэй /Улсын төсөв болон Гадаад зээл, тусламж/	2,137,700.0	1,192,599.0
Барих шилжүүлэхээс бусад нөхцөлтэй концесс	12,779,774.0	9,744,715.2
Хувийн хэвшлийн санхүүжилт	6,231,460.5	5,317,460.5
Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй	7,374,054.9	4,709,308.9
Нийт	38,287,190.9	28,323,606.6



УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 2018-2021

НИЙТ ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД


№	Эх үүсвэр	Тоо	Хувь
Нэг.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт төслийн тоо	10	9%
Хоёр.	Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих нийт төслийн тоо	57	50%
Гурав.	Холимог эх үүсвэртэй /Улсын төсөв болон Гадаад зээл, тусламж/	10	9%
Дөрөв.	Барих-шилжүүлэхээс бусад нөхцөлтэй концесс /концесс BOT, DBOT, FOT, DBOO/	14	12%
	Тав. Хувийн хэвшил	11	10%
	Зургаа. Эх үүсвэр шийдэгдээгүй	11	10%
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шилжин хэрэгжих төслийн тоо	113	100.00%



- Улсын төсөв
- Гадаад зээл
- Холимог эх үүсвэр
- Концесс
- Хувийн хэвшил
- Эх үүсвэр шийдэгдээгүй

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 2018-2021 НИЙТ ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД


№	Эх үүсвэр	Тоо	Хувь
Нэг.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт төслийн тоо	5	12%
Хоёр.	Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих нийт төслийн тоо	29	67%
Гурав.	Холимог эх үүсвэртэй /Улсын төсөв болон Гадаад зээл, тусламж/	7	16%
Дөрөв.	Барих-шилжүүлэхээс бусад нөхцөлтэй концесс /концесс BOT, DBOT, FOT, DBOO/	2	5%
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шилжин хэрэгжих төслийн тоо	43	100.00%



■ Улсын төсөв
 ■ Гадаад зээл
■ Холимог эх үүсвэртэй
 ■ Концесс

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 2018-2021 ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

№	Эх үүсвэр	Тоо	Хувь
	Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт төслийн тоо	5	7%
	Хоёр. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих нийт төслийн тоо	28	40%
	Гурав. Холимог эх үүсвэртэй /Улсын төсөв болон Гадаад зээл, тусламж/	3	4%
	Дөрөв. Барих-шилжүүлэхээс бусад нөхцөлтэй концесс /концесс BOT, DBOT, FOT, DBOO/	12	17%
	Тав. Хувийн хэвшил	11	16%
	Зургаа. Эх үүсвэр шийдэгдээгүй	11	16%
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шилжин хэрэгжих төслийн тоо	70	100.00%



ТХХТ-Н БОДЛОГЫГ ШИНЭЧЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

- Газар зүй, уур амьсгал, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал ойр улс орнуудын туршлагыг судлах,
- УИХ-аас 2009 онд баталсан ТХХТ-ийн бодлого, 2010 оны Концессын тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх, түүний алдаа оноог дэнслэн сайжруулах хувилбарыг судлах,
- Монгол улсын нөхцөлд тохирсон ТХХТ-ийн загварыг сонгох, эсвэл судалгааны үндсэн дээр өөрийн орны онцлогт тохирсон хувилбарыг боловсруулах,
- Азийн Хөгжлийн Банкны “ТХХТ-ийн таатай орчинг бүрдүүлэх” төслөөс өгсөн санал, зөвлөмж
- Тусгаар улсуудын хамтын ажиллагааны байгууллагын ТХХТ-ийн тухай загвар хууль (2014),
- НҮБ-ийн Олон улсын худалдааны хуулийн байгууллагаас гаргасан Хувийн хэвшлийн санхүүжилтээр дэд бүтэц байгуулах төслүүдийн эрх зүйн баримт бичиг боловсруулах удирдамж (2001)-ийг харгалзан үзэх
- ТХХТ-ийг хэрэгжүүлэх институцийн тогтолцоо,
- ТХХТ-ээр хэрэгжүүлэх төслийн судалгаа, хөгжүүлэлт
- Эрсдэл хуваарилах зарчим

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС


- ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлоготой үзэл баримтлалыг уялдуулах,
- Хуулийн зорилт, ТХХТ-ийн тухай хууль тогтоомж, хамрах хүрээ,
- ТХХТ-ийн хүрээнд Төр болон хувийн хэвшлийн тогтвортой, үр дүнтэй, харилцан ашигтай харилцан ашигтай практик шаардлагад тулгуурласан байх зарчим баримтлах
- Нэр томъёог жигдрүүлэх, зохицуулалтуудын уялдаа холбоог боловсронгуй болгох,
- Улсын Их Хурал, Засгийн газар, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын бүрэн эрх, чиг үүрэг
- ТХХТ-ийг төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэх,
- Төслийг сонгох, эрэмбэлэх, эрсдэлийн шинжилгээ хийх, санхүүгийн чадавхийг тогтоох зэргээр төслийн судалгаа хөгжүүлэлтэнд илүү ач холбогдол өгөх,
- Түншлэгчийг ил тод, өрсөлдөөн дээр суурилж, өндөр чадавхитай, туршлагатай хувийн хэвшлийг сонгон шалгаруулах
- түншлэлийн төрөл, хэрэгжүүлэх салбаруудын талаар, ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан тогтоох, түншлэлийн төлөвлөлт

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

- түншлэгч талуудын чиг үүрэг, хамтын ажиллагааны талаар тусгаж, төр, хувийн хэвшлийн түншлэлд оролцож буй түншлэгч талууд болон бусад оролцогчдын чиг үүрэг, оролцоо, тавигдах шаардлага
- талуудын хооронд эрсдэл хуваарилалтын талаарх зохицуулалт, эрсдэлийн удирдлагын талаар болон түншлэлийн хүрээнд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны асуудал
- ТХХТ-ийн гэрээ байгуулах асуудал, уг гэрээний нөхцлөийн талаарх суурь зохицуулалтыг төслийн онцлогт тохируулан уян хатан томъёолж, шууд гэрээ байгуулах нөхцөл, түншлэлийн гэрээнд тавих хяналт,
- ТХХТ-ийн Үндэсний хороо, түүний бүрэлдэхүүн, эрх хэмжээний талаарх зохицуулалт
- ТХХТ-ийн сан, уг сангийн хөрөнгийг бүрдүүлэх болон захиран зарцуулах, ТХХТ-ийн ил тод байдал, түншлэлийн талаарх мэдээлэл, тайлагналт, мөн төслийн хэрэгжилтийн мониторинг болон үнэлгээ
- ТХХТ-ийн хүрээн дэх маргааныг шийдвэрлэх асуудал, хариуцлага хүлээлгэх үндэслэл, ТХХТ-ийн тухай хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО, ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛЭЭС ХҮЛЭЭХ ҮР ДҮН ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО

Салбар	Компанийн хүлээлт	Орон нутаг, төрийн хүлээлт	Иргэдийн хүлээлт
Хууль эрх зүйн хүрээнд	Эрсдлийг хуваалцах бодлого, хууль эрхзүйн орчин Хэрэгжүүлэх институцийн тогтвортой байдал	Орон нутгийн хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүд Төслийн хүрээнд хамтран ажиллах, ажлын байр нэмэгдүүлэх	Өрхийн орлогод нөлөөлөл багатай байх,
Ёсзүйн хүрээнд	Шударга ил тод нээлттэй сонгон шалгаруулалт, авилгалаас ангид байх	Орон нутгийн түгээмэл тархацтай түүхий эд материалыг байгаль орчинд ээлтэйгээр ашиглах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах нийгмийн хариуцлагатай байх	ТХХТ хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдэх, амьдралын чанар дээшлэх, шинэ мэргэшил, шинэ туршлага эзэмших
Эдийн засгийн хүрээнд	Оролцогч талууд үр ашигтай ажиллах,	ТХХТ-н төсөл хэрэгжсэнээр компани, ЖДҮ, бичил бизнесийн оорчин сайжирч, иргэд үр шимийг хүртдэг байх	Нийгмийн үйлчилгээнд гарах зардал буурах, үр ашиг нэмэгдэх, Энгелийн үзүүлэлт сайжрах
Нийгмийн хүрээнд	Нийгмийн болон дэд бүтцийн төслүүд хэрэгжсэнээр үйлчилгээ сайжрах	Ядуу иргэдийг сургах замаар ажлын байраар хангах	Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх
Байгаль орчны хүрээнд	Байгаль орчинд эерэг технологи ашиглах	Байгаль орчны нөхөн сэргээлт, байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах	Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх

The image shows the national flag of Mongolia, which is divided into three horizontal stripes: a top blue stripe, a middle red stripe, and a bottom green stripe. In the center of the red stripe is a yellow sun with a flame on top, and a yellow crescent moon below it. The flag is shown waving, with a blue sky in the background.

МОНГОЛ УЛС ҮҮРД ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ,
МОНГОЛ ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ
БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ
АМЬДРАХ БОЛТУГАЙ.